

Монголын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын  
Ажлын хэсгийн 42 дугаар хуралдааны тэмдэглэлд

2016Оны 11-р сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн 42 дугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр (Баасан гараг)-ийн 09.30 цагт Татварын Ерөнхий Газрын хурлын танхимд эхлэж, 12,35 цагт дуусав. Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч Н.Энхбаяр нээж, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал удирдав.

Хэлэлцсэн асуудлууд, хуралдаанаас санал нэгтэй гаргасан шийдвэрүүд:

1. Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн төслийг Улаанбаатар аудит корпорацийн ахлах аудитор Эрдэнэцог, Их Британийн Харт Нойрс компанийн захирал Дэвид Күн нар танилцуулав. Хуралдаанаас шийдвэрлэсэн нь:
  - i. Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн төсөлтэй танилцаж хангалттай гэж үзэв.
  - ii. Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны нэгтгэл тайланг Үндэсний зөвлөлд танилцуулахад бэлтгэх нь зүйтэй гэж үзэв.
  - iii. ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг 12 дугаар сард зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв. Үндэсний Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг ОҮИТБС-ын Ажлын албанд үүрэг болгов.
  - iv. Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 хувийн төлбөрийг шилжүүлэхийг Ажлын албанд санал болгов.
2. Монголын Олборлох үйлдвэрлэлийн компаниудын ашиг хүртэгч эздийг ил болгох замын зураг хөтөлбөрийг УУХҮЯ-ны Ул уурхайн газрын ахлах мэргэжилтэн Д.Дамба танилцуулав. Хуралдааны явцад гишүүдээс гаргасан саналыг “замын зургийн” төсөлд тусган боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ОҮИТБС-ын Ажлын албанд үүрэг болгов.
3. Монгол ОҮИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөний төслийг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. Хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг 2017 оны ажлын төлөвлөгөөний төсөлд нэгтгэн шинэчилж, Үндэсний зөвлөлд танилцуулахад бэлтгэхийг ОҮИТБС-ын Ажлын алба /Ш.Цолмон/-нд үүрэг болгов.

Тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч

Н.Энхбаяр

Татварын ерөнхий газрын дарга (907)

Б.Заяабал

Тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,  
Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн

А.Огтонтунгалаг

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2016-11-18/**

Ажлын хэсгийн 42 дугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 9.30 цагт Татварын ерөнхий газрын байрны 7 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Н.Энхбаяр, Татварын ерөнхий газрын дэд дарга Б.Заяабал, ТУХАГазрын дарга н.Бадрал, УТОХГазрын ЭБОУХ-ийн дарга н.Баяраа, ахлах мэргэжилтэн Батцэнгэл, УТОХГ-ын мэргэжилтэн н.Болд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Д.Дамба, Засгийн газрын ахлах референт Э.Сумьяа, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Г.Оюунтуяа, Авлигатай тэмцэх газрын мэргэжилтэн н.Баярцэцэг, Сангийн яамны НББ-ийн газрын мэргэжилтэн Г.Зулай, Байгал орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Б.Саран, мэргэжилтэн М.Тулга, Транспаренси интернэйшнл-Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-од, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын дарга Л.Долгормаа, МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Алт үйлдвэрлэгчдийн холбооны ажлын албаны дарга Э.Агиймаа, Бороо гоулд ХХК-ийн ахлах нягтлан бодогч П.Болормаа, Петроматад ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Амарзул, Оюутолгой ХХК-ийн мэргэжилтэн н.Ренчинпагма, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 20 гишүүн оролцож ирц 60,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпорацийн захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, Их Британийн Харт Нойрс компанийн захирал Дэвид Куин нар болон бусад аудиторууд, Гаалын ерөнхий газрын мэргэжилтэн н.Батцэнгэл, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг болон Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Н.Энхбаяр нээж, хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулснаар хурал эхлэв.

Н.Энхбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, хуралдааны ирц бүрдэж байгаа тул хурлаа эхэльье. Хөтөлбөр ёсоор Монголын ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 42 дугаар хуралдаанаар үндсэн гурван асуудлыг хэлэлцэнэ, Та бүхэнд урьдчилан цахим хэлбэрээр хүргүүлсэн байгаа, танилцсан байх. Асуудал тус бүр дээр шийдвэр гаргаж, тэмдэглэл боловсруулж тараасан. Ингээд Ажлын хэсгийн 42 дугаар хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн та бүхэндээ талархал илэрхийлье. Мөн Монголын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн дарга, Монгол улсын ерөнхий сайдын нэрийн өмнөөс та бүхэнд талархлаа дахин илэрхийлье. Монгол улсад ОҮИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллана гэдэгт Та бүхэнд найдаж байна.

Өнгөрсөн сонгуулиас хойш Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлагдаж, ирэх оны төсвийн үндсэн чиглэл, үндсэндээ ирэх дөрвөн жилд хийгдэх ажлууд хэлэлцэгдэн гараад байна. Өнөөдөр эдийн засгийн байдал

хүндхэн, амаргүй байгааг та бүхэн мөнгөний бодлогын хэлэлцүүлгийн явцад тодорхой харсан байх. Энэ оны хувьд эдийн засгийн өсөлт маань оны эхний 9 сарын байдлаар -1,6 хувьтай гарч байна. Ирэх онд гадаад өр төлбөр, дотоод өр төлбөр гэсэн нилээн их ачаалалтай жил байгаа. Өнгөрсөн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг 17%-д хүргэхэд манай уул уурхайн салбар ихээхэн хувь нэмэр оруулсныг та бүхэн мэдэж байгаа. ДНБ-ийн 40-45%-ийг аж үйлдвэрийн компаниуд, 90 гаруй хувийг манай олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдхүүн эзэлж байгаа. Гэвч энэ нь бүтээгдхүүний үнэ ханшийн өсөлт бууралтаас шууд шалтгаалдаг. Энэ салбар нь үндсэндээ хөрөнгө санхүүжилтийн хувьд ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалтад тулгуурладаг. Иймд бид нэгдүгээрт, эдийн засгийн байдлаа төрөлжүүлэх шаардлага байгаа, хоёрдугаарт бүхий л салбарт орж ирж байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн тогтвортой байлгах вэ гэдэг асуудал нь Улсын их хурал, Засгийн газрын бодлогын нэн чухал хэсэг болоод байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын дэргэд хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хангах зөвлөл байгуулж байгаа. Энэ чиглэлээр бид монгол улсад хөрөнгө оруулж байгаа хөрөнгө оруулагчдаа тогтвортой байлгах, ажиллах тааламжтай орчин нөхцлийг бүрдүүлэхэд илүү анхаарч ажиллаж байгаа.

ОҮИТБС-ын маань Дэлхийн банкны тусламж дэмжлэгээр өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж байна, тодорхой ахиц дэвшил авчирч байна. Энэ төслийн ач холбогдол нь тайлан тооцоо, тоон мэдээллийг нийцүүлэх боловч хамгийн гол ач холбогдол нь Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хооронд итгэлцэл бий болгох зорилготой. Иймд хөрөнгө оруулагч болон Засгийн газар хамтарч ажиллах бололцоог олгож байгаа учраас нилээд ач холбогдолтой санаачилга байгаа. Олон улсын түвшинд Монгол улсын ОҮИТБС-ын гаргасан тайлан нилээд хүлээн зөвшөөрөгдсөн, саяхан 2016 оны 10 дугаар сард Казахстан улсын Астана хотноо ОҮИТБС-ын олон улсын уулзалт болсон.

Өнөөдөр бид 2006 оноос хойш хэрэгжүүлж байгаа ОҮИТБС-ын 10 дахь удаагийн тайлангаа хэлэлцэх гэж байна. Тайлан гараг явцад тодорхой шалтгааны улмаас цаг хугацааны хувьд хойшилсон боловч өнөөдөр тайлан маань бэлэн болж, бид хэлэлцэх гэж байна. Цаашдаа 12 дугаар сард Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх болно. Цаашид шинээр тавьж байгаа зорилт бол ОҮИТБС-ын хувьд олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын ашиг хүртэгч эздийг ил болгох гэсэн зорилтын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан, 2016-2019 онд Монгол улсад олборлох үйлдвэрлэл эрхлэгч, ашиг хүртэгч эздийг ил болгох, 2020 оноос эхлэн ашиг хүртэгч эздийг ил болгоно гэсэн стандартын шаардлагад нийцэхийн төлөө зорьж ажиллах болно. Та бүхэн төлөвлөгөөний хэлэлцүүлгийн үеэр саналаа өгнө гэдэгт найдаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, нээлттэй нийгэм форумтай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах, гэрээний ил тод байдлыг хангаж ажиллахад идэвхтэй ажиллах болно. Мөн Европыг сэргээн босголт банкнаас дэмжлэг тусламж авч, хамтран ажиллахаар хоёр тал ойлголцон ажиллаж байна. Хуралдааны явцад амжилт хүсье, Та бүхэнд хуралдаандаа идэвхтэй оролцоорой.

Хуралдааны дотоод журмыг баталъя. Хурлын дотоод журмыг танилцуулж, гишүүд 100 дэмжив.

## **I. ХЭЛЭЛЦЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн төслийн танилцуулга**

Д.Куин: Харт групп нь ОҮИТБС-ын тайланг хэд хэдэн жил хийж байна. Харт групп нь Их Британид байрладаг, ОҮИТБС-ын нэгтгэл, баталгаажуулалтын ажлыг

хийж байсан. Дэлхийн нилээд олон улс орнуудад санаачилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан байгууллага юм. Мөн санаачилгад оролцож байгаа ИНБ-уудад чадавхийг бэхжүүлэх сургалт явуулах, төрийн байгуулалтуудтай хамтран баталгаажуулалт хийх зэрэг үйл ажиллагааг явуулдаг. Харт Нойрс групп нь Монгол улсын Улаанбаатар аудит корпорацитай хамтран ажилладаг, тус байгууллага нь Монгол улсын нилээн томоохон компаниудын нэг ба аудит баталгаажуулалт, аудитын зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага юм. Улаанбаатар аудит корпораци нь Дэлхий дээр томоохонд тооцогддог, үйл ажиллагаа явуулдаг Грант Торnton гэдэг сүлжээ байгууллагын гишүүн байгууллага юм.

Одоо та бүхэнд тайлангийнхаа төслийг танилцуулах гэж байна. Зарим нэг мэдээллийг тодруулах үйл ажиллагаа хийгдэж байна, цаашид улам сайжирч өөрчлөгдөнө гэдгийг анхаараарай.

Энэхүү тайлан нь 2015 онд олборлох үйлдвэрлэл явуулсан 202 компани, 10 төрийн байгууллага, орон нутгийн төр захирагааны байгууллагуудын мэдээллийг хамруулж хийгдсэн. Компаниудын зүгээс төлсөн татвар, засгийн газрын зүгээс хүлээн авсан орлогоос гадна нэмэлт мэдээллүүдийг хамруулсан. Нэгтгэл хийхдээ цахим тайлангийн мэдээллийг тайландаа ашигласан. Төрийн байгууллагуудын зүгээс хүлээн авсан орлогыг татвар төлсөн компани бүртэй тулган шалгах замаар боловсруулсан. Нэгтгэлд 191 компани, 11 ТӨК-иудын орлогын урсалаар хязгаарлагдсан. Томоохон компаниудыг эхлээд сонгож авсан, Засгийн газрын зүгээс 1,4 их наяд төгрөгийг хүлээн авсан байгаа. Нэгтгэл хийхээс өмнө 3,3 тэрбум төгрөгний зөрүү гарсан байсан. Талуудаас мэдээлэл, тодруулга аваад нэгтгэлээ хийгээд үзэхэд 1,44 тэрбум төгрөг болтлоо буурсан байгаа. Энэ бол томоохон амжилт юм, зөрүүний цаана бас шалтгаан байсан. Үүнийг цааш нь тохируулсаар 200 сая төгрөгний тайлбарлагаагүй зөрүү үлдсэн. Бидний зүгээс хамтран ажилласан төрийн байгууллагуудад талархлаа илэрхийлэхийг хүсэж байна.

Хамгийн их татвар хураамж төлсөн 10 компани нийт татвар хураамжийн 88 орчим хувийг төлсөн байхад, үлдсэн 2000 гаруй компани нь 12 орчим хувийг төлсөн байх жишээтэй сонирхолтой мэдээллийг харж болно.

Нэгтгэл тайлангийн талаар тайлангийн иж бүрэн байдал, баталгаажуулалт, бусад гэсэн байдлаар товч танилцуульяа. Бид бол хараат бус нэгтгэгч гэдэг байдлаар хоёр талын тайлагнасан компанийн 96,1 %-ийг тайландаа хамруулсан нь тайлан иж бүрэн болсон байна гэж үзнэ. Бүх төрийн байгууллагууд, ТӨК-ууд хамрагдаж, тайлангаа гаргаж өгсөн. Тайлангаа компанийн удирдлага тайлан үнэн зөв гэдгээ баталж удирдлагын хариуцлагын захидал буюу төлөөллийн захидал явуулах ёстой. Төрийн байгууллагууд уг захидалыг ирүүлээгүй байна. Уг тайлан гаргасан албан тушаалтан энэхүү мэдээлэл үнэн зөв гэсэн баталгаа гаргаж өгөх нь мэдээлэл чухал ач холбогдолтой. Энэ нь төлсөн болон хүлээн авсан талуудын тоо мэдээ таарвал нэгтгэгчийн хувьд цааш үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болох юм. Одоо нэг байгууллагын захидалыг хүлээж байна. Мөн ТӨК-иас өөрсдийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа явуулахыг хүссэн. Одоогоор дөрвөн ТӨК ирүүлээгүй байна. Нийт компаниудын 76% нь тухайн мэдээллээ үнэн зөвийг батласан удирдлагын захидалыг явуулсан, 46 % нь аудитлагдан санхүүгийн тайлангаа явуулсан байна. Өнгөрсөн жил аудитын дүгнэлт явуулж байгаагүй, энэ жил бараг 50 хувь нь аудитын захидал явуулсан нь томоохон ахиц гарсан. Яагаад эдгээр захидал, аудитлагдан санхүүгийн тайлангийн талаар яриад байна вэ гэвэл нэгдүгээрт, ОҮИТБС-аас биднийг шаардсан байгаа, хоёрдугаарт ОҮИТБС-ын стандартад хэрвээ тайлан гаргаж байгаа компаниуд сайн тайлан, удирдлагын хариуцлагын захидалтай байгаад, хүлээн авсан талын орлоготой таарч байвал баталгаажуулалт хийх шаардлагагүй болно гэж үзэж байгаа. Одоогийн байдлаар

нийт компаниудыг  $\frac{1}{4}$ -нь удирдлагын төлөөллийн захидлаа явуулаагүй байна. Энэ нь ОҮИТБС-ын тайлан гаргаад 10 жил болж байхад яагаад төлөөллийн захидлаа явуулж суралжийн гэдэг асуудал байгаа. ТӨК-иудын зүгээс аудитын захидлаа явуулсан боловч зарим мэдээлэл дээр хязгаарлалт тавьсан байсан. Тухайлбал, нягтлан бодох бүртгэлийн хувьд, нөхөн сэргээлт, үйл ажиллагааны бүтцийг сайжруулах гэх мэт зарим хязгаарлалтууд байсан.

Тайлангийн бусад асуудлын тухайд, 2015 онд бүтээгдхүүн хуваах гэрээнүүд хийгдсэн байгаа, үүнийг ил тод болгох шаардлага байсан бөгөөд мэдээллийг гаргаж өгнө үү гэсэн боловч гаргаж өгөөгүй. Мөн тухайн тайлан гаргасан жилийн лицензийн хөдөлгөөн, өөрчлөлтийг ил тод болгож чадахгүй байгааг ил тод болгох шаардлага байсан. Бид тавигдсан шаардлага дээрээ үндэслэн 2015 онд хамарагдах лицензийн өөрчлөлтүүдийг авч үзэхэд зөрүүтэй зүйл байсан. Энэ нь мэдээллийг боловсруулах, оруулахад алдаа гарсан, өөр өөр төрлийн мэдээллийн сангудын мэдээллийг ашигласнаас болсон байж болно, иймд үүнийг цаашид судлах шаардлагатай гэж үзсэн. Цаашилбал, үйлдвэрлэсэн бараа бүтээгдхүүний тоо хэмжээ, үнийг тайландаа тусгасан байх шаардлага ОҮИТБС-ын стандартад тавигдсан. Бид мэдээллийг тодорхой хэмжээгээр авсан, нүүрсний үйлдвэрлэсэн тоо хэмжээ, борлуулсан үнийн мэдээллийг авсан. Бид тайлангийн нэгтгэл хийхдээ хэд хэдэн зөвлөмжүүдийг гаргасан. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Заяабал: Та бүхэнд баярлалаа. Харт групп 2013 онд нэгтгэл тайланг гаргаж байсан, туршлагатай компани байна. ОҮИТБС-ын стандарт шаардлагад өөрчлөлт орсон байна. Танилцуулгатай холбогдуулан асуулт байвал асууж болно.

Б.Батболд: ОҮИТБС-ын нэгтгэл тайланг бэлтгэж байх явцад Олон улсын баталгаажуулалт хийгдсэн. Үүнийг харсан уу, эндээс дараагийн ч юм уу нэгтгэлийн үйл ажиллагаанд авах зөвлөмж санал байсан болов уу.

Д.Куин: Баталгаажуулалтын тайлан одоогоос 4-5 долоо хоногийн өмнө ирсэн. Үүнээс гарсан зөвлөмж саналыг тайландаа тусгая гэхээр хугацааны хувьд бага байсан. Баталгаажуулалтыг тайлангаас гарсан санал зөвлөмжийг ажлын хэсэг ажлын төлөвлөгөөндөө оруулаад, дараа жилийн ажлын даалгавар дээр тусгаж ажиллавал илүү үр дүнтэй байх болов уу гэж үзсэн.

П.Амарзул: Төрийн байгууллагуудын удирдлагын захидал байхгүй байна гэсэн. Үүнийг хэн хариуцаж, баталгаажуулах ёстой вэ, ямар арга хэмжээ авах юм бол?

Н.Эрдэнэцог: Төрийн байгууллагуудын хувьд нэг ч байгууллага гаргаагүй. Нэгтгэл тайлангийн тоон мэдээлэлтэй холбоогүй суурь мэдээлэлтэй хамаарах мэдээлэл авахыг хүссэн. Төрийн байгууллагууд уг тайлан мэдээг хариуцсан ажилтнууд байгаа боловч үүнийг олж авахад тун хэцүү байсан. Шинэ засаг байгууллагдсантай холбоотойгоор мэргэжилтнүүд солигдсон байна. Үүнээс болоод хүндрэлтэй байна. Бид олон мэдээллийг тулгаж, хамгийн зөв гэснийг тайландаа оруулж байна. Төрийн байгууллагын мэдээллийг үнэн зөв гэдгийг ахлах, дээд удирдлагууд нь баталж өгөх ёстой, үүнд төрийн байгууллагууд хангалтгүй ажиллаж байгаа.

Д.Куин: Тухайн төрийн байгууллагын удирдлага өөрсдийн гаргасан тайлан мэдээллийг үнэн зөв гэдгийг баталсан захидалтыг тайлан гаргаж дуусахаас өмнө өгөх ёстой.

Т.Амарзул: Асуулт маань, удирдлагын захидал гаргаж өгөхгүй байгаа төрийн байгууллагуудтай яж ажиллах вэ, хэн тэр захидалтыг гаргуулах ёстой вэ?

Н.Бадрал: Татварын байгууллага хүссэн тайлан мэдээллийг гаргаж өгнө, зөвхөн нэг л мэдээллийг гаргаж өгөхөөс татгалздаг. Өөрөөр хэлбэл татвар төлөгчийн нэр дугаараар, татвар төлөгч зөвшөөрөөгүй тохиолдолд аливаа мэдээллийг өгөх боломжгүй, харин статистик мэдээллийг гаргаж өгдөг.

Э.Сумьяа: Төрийн байгууллагын төлөөллүүд гаргасан тайлангаа баталгаажуулах захидалтыг тайлан гарахаас өмнө өгөх хэрэгтэйг удирдлагууддаа дамжуулж, гаргуулмаар байна. Хэрвээ тайлан гарахаас өмнө өгөхгүй бол хариуцлага тооцдог болмоор байна. Энэ нь зөвхөн нэг компанийн талаар ярьж байгаа зүйл биш, улсын хэмжээний тайлан мэдээллийн тухай яригдаж байна. Нөгөө талаар зарим зөвлөмж нь хэрэгжих боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын хууль тогтоомж энэ зөвлөмжийн дагуу өөрчлөгдөх гэсээр байтал хугацаа ороод байна. Бид хууль батлуулах гээд явсаар байгаад чадсангүй, зарим зөвлөмжүүд нь тээг болоод байна. Гэрээг ил болгоно гэхээр байгууллагын нууц гээд ил тод болгож чадахгүй байна, харин гэрээний биелэлтийг дүгнэх гэвэл болж байна. Иймээс аудитын байгууллагууд зөвлөмж өгөхдөө үг хэллэгийг зөв олж тавих, тэр нь биелэгдэхүйц байлгах хэрэгтэй байна.

Г.Оюунтуяа: АМГ-ын мэргэжилтэн, 2013 онд ОҮИТБС-ын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан, тухайн үед цахимаар мэдээлэл, баталгаажуулалтын захидаа явуулдаг байсан. Энэ жилийн хувьд яагаад удирдлагын захидаа өгөөгүй байгааг сайн мэдэхгүй байна, би энэ ажлыг саяхан авсан, үүнээс хойш энэ тухай Улаанбаатар аудит ямар нэг юм хэлээгүй, бусад мэдээллийг шаардлагын дагуу гаргаж өгсөн байгаа. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар тухайн сонирхож байгаа байгууллагууд манай байгууллагад бүртгүүлээд, эрхээ нээлгээд дуртай мэдээллээ харах боломжтой байгаа. Одоогоор хүн болгон ороод байх боломж байхгүй, цахим сан маань ачаалал даах чадвар муу, олон зэрэг орох боломжгүй байна. Энэ асуудал дээр манай дарга анхаарал хандуулж ажиллаж байгаа, мэдээллийн сан байгуулаад түүндээ бүх мэдээллийг нэгтгэнэ. Манай байгууллагаас ямар нэгэн мэдээллийг нуусан хаасан зүйл байхгүй, аль болох нээлттэй ажиллахыг зорьж байгаа.

Б.Заяабал: Төрийн байгууллагууд мэдээллээ гаргаад өгчихсөн юм байна. Түүнийхээ хойноос энэ мэдээлэл үнэн зөв гэдгээ баталсан удирдлагын захидал явуулчих гээд байгаа юм байна. Тайлангийн маягтаа хоёр талаас батлаж байгаа нь манайх энэ мэдээллийг гаргаж өгөхийг зөвшөөрч байна л гэсэн үг, өөрөөр хэлбэл удирдлагын зөвшөөрөл нь юм. Дахиад захидал шаардаж байгаа юм байна, тайлангаа өгсөн юм чинь энэ нь асуудал биш шүү.

П.Болормаа: Энэ жилийн хувьд төрийн байгууллагаас ирсэн мэдээ сайн ирсэн, ямар ч зөрүүгүй дүнгүүд байсан. Төрийн байгууллагынхан сайн ажилласан гэж харж байна. Манай компани дээр бараг зөрүү гаралтад аудит сайн хийсэн. Удирдлагын хариуцлагын захидал нь хэлбэр төдий юм. 1,3 их наяд төгрөгнөөс 200 сая төгрөгний зөрүү гэдэг бол маш бага тоо юм, материаллаг биш. Тэр их хэмжээний мэдээллийг үнэн зөв өгсөн байхад 5 байгууллага удирдлагын

хариуцлагын захидал өгөөгүй гэдгийг би агуулагад нөлөөлөхгүй гэж бодож байна. Жишээлбэл, би удирдлагын захидалыг өөрөө хариуцаж, бэлтгээд удирдлагаар гарын үсэг зуруулж өгдөг. Энэ нь хэлбэр төдий л ажил юм. Энэ жил 2 компанийн нэгтгэл дээр ажилласан, маш бага зөрүү гарсан. Төрийн байгууллагууд маш сайн ажилласан гэж бодож байна.

Л.Төр-од: Тодруулах хэдэн зүйл байна. Үүнд, Дэвидийн танилцуулга дээр баталгаажуулалт өгөхөд хангалттай нотолгоо дүгнэлт болоогүй байна гэсэн дүгнэлт хэлэх шиг боллоо, үүнийг зөв ойлгосон уу үгүй юу, тайлбарлаж өгнө үү. Мөн баталгаажуулалтын тайлантай холбоотой хариуцлага хүлээлгэх асуудал байна. Удирдлагын хариуцлагын захидалаа ирүүлээгүй, аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байгаа байгууллагад цаашдаа ямар хариуцлага хүлээлгэх вэ? Үүнд тогтох ярилцах нь зүйтэй байх. Тайлан хийгдэж байх үе буюу 7 дугаар сард Хөдөлмөрийн яам, БОАЖ яам зэрэг байгууллагууд тайлангаа оруулаагүй л байсан. Тайлан бичих явц хүртэл төрийн байгууллагууд удирдлагын хариуцлагын захидалаа ирүүлээгүй байсан, үүнд ямар хариуцлага тооцох вэ? Цаашилбал төрийн байгууллагын зарим хүмүүс зөвлөмжтэй холбоотой асуудлаар хэлэхдээ хууль тогтоомж нь чөдөр болоод байна гэж байна. Би арай өөр байр суурьтай байна, аудитын байгууллага стандартынхаа дагуу ямар шаардлага тавих ёстой, юу хэрэгжиж байгаа талаар зөвлөмж өгөх эрхтэй. Харин биелэгдэхгүй зөвлөмж өгөөд байна гэж хараат бус нэгтгэгч юм уу аудитын байгууллагыг буруутгах нь буруу гэж үзэж байна, стандартын дагуу ажиллаж, өгөх зөвлөмжөө өгөх хэрэгтэй, харин үүрэг хүлээснийхээ хувьд төрийн байгууллагууд чөдөр тушаа болоод байгаа хууль тогтоомжкоо хэрхэн яаж өөрчлөх вэ гэдэг дээр санал санаачилгатай ажиллах хэрэгтэй байна. Саяхан 2016 оны 11 сарын 3-нд Улсын их хурлаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлагдсан байгаа, үүний ажлын хэсэгт би орж ажилласан. Тус хөтөлбөрийн 4.1.6-ийн 5-д Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах гэсэн заалт орсон. УИХ өөрөө холбогдох бүх хууль тогтоомжийг батална гэсэн үүрэг хүлээсэн байгаа, өөрөөр хэлбэл олборлох үйлдвэрлэлтэй холбоотой хууль тогтоомжийг батална. Цаашилбал төрийн байгууллагын нууцын тухай, хувь хүний нууцын тухай хуулийг эргэж харахаар байгаа. Ирэх жилээс ОУИТБС-ын шинэ стандартыг бүрэн дүүрэн хангахын тулд хамтран ажиллахад зүйтэй гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Куин: Мэдээллийн баталгаажуулалттай холбоотой асуулт байна. Төрийн байгууллагын тайлан хариуцсан хүн мэдээ тайланг бөглөөд явуулдаг. Бид тайлан мэдээг буруу гэж үзэж байгаа биш, баталгаажуулалтын удирдлагын хариуцлагын захидал заавал байх шаардлагатай гэдгийг ажлын хэсгээс гаргасан шийдвэрийн дагуу шаардаж байгаа. Төрийн байгууллагын хувьд тухай тайлан мэдээг гаргасан байгууллагын ахлах мэргэжилтэн, удирдах албан тушаалтнаар удирдлагын хариуцлагын захидал явуулахыг шаардаж байгаа нь гаргаж өгсөн мэдээллийн цаана зөвхөн тухайн ажлыг хариуцсан мэргэжилтэн биш тухайн яам, агентлаг бүхэлдээ байгаа гэдгийг баталгаажуулж байгаа санаа юм. Нөгөө талаас хараат бус баталгаажуулсан баримт бичиг шаардлагатай гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл тухайн тайланг ашиглаж байгаа хүн удирдлагын хариуцлагын захидалыг хараад хөндлөнгийн хараат бус нэгтгэгч баталгаажуулсан юм байна гэдгийг мэдэх боломжтой, энэ нь илүү итгэл төрүүлэхүйц болгож байгаа юм. Зөвхөн яам тамгын газар бус 21 аймаг, орон нутгийн захиргаанаас мэдээ тайланг баталгаажуулж өгөх шаардлагатай байгаа, энэ чухал байгаа. Компаниудын хувьд бол гаргасан мэдээллээ үнэн зөв гэдгийг баталгаажуулсан захидал эсвэл тухай компанийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг хавсаргахыг шаардаж байгаа. Энэ нь тухайн тайлан нь үнэн зөв юм гэдгээ баталсан хараат бус дүгнэлт гаргаж өгч

байгаа хэрэг юм. Энэ жил баталгаажуулалтын захидалыг 50 хувь нь гаргаж өгсөн нь дэвшил болж байгаа гэхдээ илүү сайн сайжруулах боломж байгаа. Нөгөө талаар ОҮИТБС-ын ОУ-ын нарийн бичгийн дарга К.Шорт хэлэхдээ, “Одоо гаргаж байгаа тайлан мэдээллээ цахим портал руу оруулах шаардлагатай байна” гэсэн. Монгол улс энэ ажлыг эхлүүлчихсэн байгаа, одоо цахим тайлангийн системээр тайланг нэгтгэж байгаа. ОҮИТБС-ын стандарт дээр дурдахдаа тухайн улс орны гаргаж байгаа тоон мэдээллийг хангалттай хэмжээнд байна гэж үзвэл, тухайн мэдээлэл нь цахим системд нэгтгэгдэж, түүнийг үнэн зөв гэдгийг баталгаажуулсан аудитын дүгнэлт хангалттай байвал тухайн тайлан заавал хараат бус нэгтгэгч тулгалт хийж, нэгтгэх шаардлагагүй болно гэж дурдсан байдаг. Хэдийгээр цахимаар тайлан авч байгаа ч энэ жилийн хувьд ирүүлсэн удирдлагын хариуцлагын захидал, аудитын дүгнэлтийг харахад тэр хэмжээнд арайхан хүрээгүй гэж үзэж байна. Энэ дээр үндэслээд цаашид сайжруулах арга хэмжээг авч байр нь зүйтэй.

н.Батцэнгэл: Тайлангийн зөрүү 3,3 тэрбум төгрөг байсан байна. Үүнийг харилцан тохиролцсоны дунд 0,2 тэрбум төгрөг хүртэл тохируулсан байгаа. Ийм үр дунд хүрэхэд ОҮИТБС-ын ажлын алба, Улаанбаатар аудит болон бусад байгууллагуудад талархал илэрхийлье. Бид энэ зөрүүг гаргахын тулд хамтарч ажиллаж байсан, 100 гаруй аж ахуйн нэгж дээр хамтарч ажилласан, нилээд том ажил болсон. Манай байгууллага маягт 1, тодруулга 5-ыг гаргадаг. Одоо цахимаар гаргадаг, хуучин цаасаар өгдөг байсан. Байгаа мэдээллийг байгаагаар нь өгч байгаа, нуусан хаасан юм байхгүй. Цаашилбал, бид дуртай мэдээллээ орж харах боломжтой системтэй болох талаар ярилцаж байгаа. Дахин хэлэхэд энэ нэгтгэлийг хийсэн Осоргарав захиралтай Улаанбаатар аудитын хамт олонд талархлаа илэрхийлье.

Б.Саран: ОҮИТБС-ын 2015 оны тайлангийн нэгтгэл дээр БО-ны барьцаа хөрөнгө, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл орсон байгаа. Бидний зорьж байгаа асуудал бол яаман дээр бэлэн байгаа мэдээллээс гадна тухайн аж ахуйн нэгж байгууллагын нөхөн сэргээлтийн чиглэлээр хүлээж байгаа үргийн талаар тухайн эвдэгдсэн газар, нөхөн сэргээсэн газрыг компани бүрээр гаргаж, мэдээллийг тайланд оруулах явдал байсан. Ноднин энэ талаар ажлын хэсгийн хурал дээр санал тавиад, санал маань тодорхой үр дунд хүрч 2015 оны тайланд орж байгаад талархалтай байна. Цаашидаа 2016 оны тайлангаас эхлээд саяны ярьдаг хэлбэрээр компани бүрээр мэдээлэл гаргаж өгөх тал дээр нарийвчилж ажиллаж өгөөсэй. Тэгвэл ил тод байдлын тайланд нөхөн сэргээлтийн талаар мэдээ мэдээлэл ил болох юм. Үнэндээ АМГ болон манай яам аль аль нь нөхөн сэргээгдсэн газрын мэдээг тоогоор хэлж чадахгүй байгаа, жил бүр өссөн дүнгээр яваад байгаа. Компаниуд маань өөрсдөө тухай жилд эвдсэн газраа, нөхөн сэргээсэн газраа ил тод мэдээлээд байвал цаашидаа нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл ил тод болно. Хэрвээ ингэж чадвал ил тодын тайланд томоохон ахиц гарна гэдгийг хэлээд, энэ саналыг цааш нь үргэлжлүүлээд яваасай. Манай яамны хувьд энэ жил өөрт байгаа нөхөн сэргээлтийн мэдээлэл, барьцаа хөрөнгийн мэдээллийг албажуулаад явуулсан. Барьцаа хөрөнгийн асуудлыг тайланд ил тод тавих гэсэн боловч нууцын хуулиараа барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл нууцын зэрэгт байгаа учраас мэдээлж болохгүй байгаа, харин эвдэгдсэн газар нөхөн сэргээсэн газрын талаарх мэдээллийг ил тод болговол компаниудын өөрсдийнх нь нэр төр, имидж болон бизнесийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр зөв эерэг нөлөөлөл үзүүлэх болов уу. 2017 оны төлөвлөгөөнд мэдээллээ аваад тавих боломжтой гэсэн саналыг хэлье.

Б.Осоргарав: 2015 оны нэгтгэл тайланд хамтран ажилласан бүх байгууллага хамт олонд талархал илэрхийлье. Энэ жилийн нэгтгэл тайлан хугацааны хувьд оройтож эхэлсэн, үндсэндээ 7 сарын сүүлээр компаниудын тайланг хүлээн авч эхэлсэн. Хэдийгээр богино хугацаанд ч гэсэн энэ ажлыг амжилттай гүйцэтгээд өнөөдөр тайлангаа тавьж байгаадаа баяртай байна.

Аудитын удирдлагын захидал нь олон улсын стандарт болон Хараат бус нэгтгэгчийн ажлын даалгаварт онцгойлон орсон учраас бид шаардсан байгаа. Үүнийг зарим байгууллагууд сайн ойлгохгүй, зарим албан тушаалтан өөрчлөгдсөн байдлаас болсон байх, энэ жилийн хувьд олон янзын шалтгаанаас болсон байх гэж бодож байна. Бүтээгдхүүн хуваах гэрээг ил тод болгох талаар Засгийн газрын 2012 оны 222 тогтоолоор батлагдсан байна гэхдээ туршилтын журмаар гэсэн учраас компаниуд ил тод болгох тал дээр төдийлөн ажиллахгүй байна. Цаашдаа шинэ Засгийн газар энэ талаар авч үзэх байхаа. Бид Үндэсний зөвлөлийн хурал дээр энэ талаар танилцуулах болно, та бүхний өгч байгаа зөвлөгөөг баяртайгаар хүлээн авч байна, та бүхэнд баярлалаа.

Г.Ганбат: 2015 оны тайланд лиценз олголттой холбоотой мэдээлэлд тойм орсон байна. Одоо цаг хугацааны хувьд амжвал, 2015 онд хичнээн өргөдөл хүлээн авч хэдийг нь олгоод, хэдийг цуцалж, одоо яг шийдвэрлээгүй хэдэн өргөдөл байгаа вэ гэдэг мэдээллийг АМГ-аас аваад, тайланд оруулах саналтай байна. Тайлангийн зөвлөмжийн 7.2.-ийн 7 дээр тайлан гарахаас өмнө ажлын алба олборлох салбартай холбоогүй компанийг хасах хэрэгтэй гэсэн байна. Энэ нь ажлын албаны хариуцах чиг үүрэг биш бөгөөд энэ нь хараат бус нэгтгэгч ямар компани нэгтгэл тайланд орох вэ, ямар мэдээлэл цуглуулах вэ гэдгийг ажлын хэсэгтэй тохиролцоод сонгох ёстой. Иймээс ажлын алба өмнөөс нь аль нь орох вэ гэдгийг нэмж хасах боломжгүй, бид тайланг хүлээн аваадаа АМГ-аас ирсэн лицензийн мэдээлэл дээр үндэслээд компаниудыг оруулдаг байгаа.

Б.Заяабал: За баярлалаа, одоо эхний асуудлыг танилцуулсан хараат бус нэгтгэгч нартаа баярлалаа, асуудалтай холбоотой шийдвэрийн төслөө гаргая. Шийдвэрийн төслийн зөвшөөрч байна уу?

Э.Сумьяа: Үндэсний зөвлөлийг зохион байгуулах гэдэг чинь ажлын хэсэг шийдэж чадахгүй, харин хуралд танилцуулах гэдэг байдлаар Үндэсний зөвлөлийн хуралдааны бэлтгэлийн хангахыг Ажлын албанд үүрэг болгов гэж оруулах санал байна.

Гишүүд шийдвэрийн төслийг дэмжиж батлав.

#### **Шийдвэрлэсэн нь:**

1. Монгол улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн төсөлтэй танилцаж, хангалттай гэж үзэв.
2. Монгол улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайланг Үндэсний зөвлөлд таницуулахад бэлтгэх нь зүйтэй гэж үзэв.
3. ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг 12 дугаар сард зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв. Үндэсний зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг ОУИТБС-ын Ажлын албанд үүрэг болгов,
4. Гэрээт ажлын үнийн дүнгийн 50 хувийн төлбөрийг шилжүүлэхийг Ажлын албанд санал болгов.

**ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын Олборлох үйлдвэрлэлийн компаниудын ашиг хүртэгч эздийг ил болгох замын зураг хөтөлбөрийн танилцуулга**

Д.Дамба: Миний бие 2016 оны 4 дүгээр сараас ажлын хэсгийн ахалж ажилласан. Бүрэлдхүүний хувьд төр, иргэний нийгэм, компанийн төлөөллүүдээс бүрдсэн нийт 16 гишүүнтэй. Өнгөрсөн хугацаанд дэд ажлын хэсэг тодорхой ажлуудыг гүйцэтгэж ирсэн байгаа. Тухайлбал, Нээлттэй нийгэм форумаас гаргасан эрх зүйн орчны урьдчилсан судалгааг хийж, тараасан. Байгалийн баялагийн зөвлөлийн хүрээлэнгээс бенефициар өмчлөгчийн ил тод болгох сургалт зохион байгуулсан. Цаашилбал дэд ажлын хэсгийн хамгийн гол ажил болох ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зураглалыг боловсруулсан. Үүнийг тулд дэд ажлын хэсэг 2 удаа хуралдаж, төслөө боловсруулсан. Төслийн боловсруулахдаа энэ чиглэлээр төсөл хэрэгжүүлж, тодорхой туршлага хуримтлуулсан 11 орны улс орнуудын туршлагыг судалсан. Судалгааны үр дүнд туршилт амжилттай болсон, хаалттай байсан асуудлууд тодорхой хэмжээнд ил тод болсон. Үндэсний зөвлөлийн гишүүд анхаарал хандуулж, ач холбогдлыг ойлгож, эрх зүйн орчныг шинэчлэх, териийн бүртгэлийн системийг нэгтгэх зэрэг асуудлыг хэлэлцэх болсон. Ажиллах явцад зарим хүндрэл бэрхшээлүүд тулгарч байсан. Тухайлбал, найдвартай, бүрэн мэдээлэл олж авахад хүндрэлтэй байсан, бенефициар өмчлөгч, хууль ёсны өмчлөгч гэсэн ойлголтыг андуурч ойлгох, ойлголтын зөрүү үүсэх зэрэг хүндрэл бэрхшээлүүд тулгарч байсан. Үүнээс гадна тодорхой боломжууд байна. Үүнд, Үндэсний бодлого стратеги тусгалаа олсон, бүрэн бус ч гэсэн институцын хүрээ бий болсон. 2020 он хүртэл замын зургийн төсөл нь 7 зорилт 33 үйл ажиллагааг төлөвлөсөн. Үүнээс 2017 онд Үндэсний бодлоготой уялдуулах, институтын хүрээг тодорхойлох, нэр томъёо, тодорхойлолт, материаллаг босго, тайлагналын хугацаа, үечлэлийг тогтоох, УТНБЭ-ийн бүрэн тайлагнал, нөлөөллийн ажил гэсэн 5 зорилтын хүрээнд, 2018 онд туршилтаар мэдээлэл цуглуулах, мэдээллийг баталгаажуулах, 2019 онд тайланг олон нийтэд ил болгох зорилтын хүрээнд тус тус тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Ашиг хүртэгч эздийг ил тод болгосноор компаниудын хариуцлага нэмэгдэх, итгэлцэл бий болох, авлигын эрсдэлийг бууруулах, шударга өрсөлдөөний орчныг бий болгоход хувь нэмэр оруулах, улмаар улс төрөөс ангид бизнес нь илүү тогтвортой эрүүл, үр ашигтай болох зэрэг ач холбогдолтой юм. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Заяабал: За баярлалаа, асуулт, санал хэлэх гишүүд байвал гараа өргөнө үү.

Л.Төр-од: 11 оронд хийсэн туршилтын үнэлгээний тайлан үзэж харсан байна гэдгийг ойлголоо. ОҮИТБС-ын удирдамжийн баримт бичиг 22-ийг харсан байх. ИНБ-уудаас мөн холбогдох хариуцах талуудаас төлөвлөгөөнийхөө төсөл дээр санал авсан уу?

Д.Дамба: Ажлын хэсгийн хүрээнд 2 удаа уулзаж, ярилцсан. 7 зорилт, 33 арга хэмжээ болгон задалж боловсруулсан. Албан ёсоор бичгээр аваагүй ч гэсэн ажлын хэсэгт орсон байгууллагуудын саналыг тусгасан.

Э.Сумьяа: Хугацааны хувьд 2020 он хүртэл гээд хугацаа хойшилсон юм шиг байна. Бодлогын асуудал байхын зэрэгцээ холбогдолгүй асуудлууд орсон байна. Үүнийг зааглаж өгөх хэрэгтэй, зарим тогтоол гэх мэт зүйлийг эндээс хасаад ажлын төлөвлөгөөнд оруулмаар байна. Бодлоготой холбоотой асуудлыг хариуцах байгууллагаар Уул уурхайн яамыг тавих хэрэгтэй. Ерөнхий сайдын хүрээнд Үндэсний зөвлөл, ажлын алба байгаа. ЗГХЭГ-тай холбоотой юм байхгүй. Би 2015 онд тэтгэвэрт гарсан, үүнээс өмнө энэ ажлын хариуцаж байсан. Надад найдаж байгаа бол хэцүү, би энэ ажлыг хариуцахгүй, өөр хүмүүс хариуцаж байгаа. ЗГХЭГ

гэж тавиад ажлаа эзэнгүйдүүлж магадгүй, иймээс бодлогын асуудлаа Уул уурхайн яам өөр дээр аваарай, эзэнгүй дунд нь үлдчих вий.

Д.Дамба: Бодлогын асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хариуцах боломжтой, Үндэсний зөвлөлийн орлогч даргаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд ажилладаг, таны саналыг хүлээн авч байна.

Б.Дэлгэрмаа: ОУ-ын стандартын дагуу 2020 оноос ашиг хүртэгч эздийг ил болгохыг заасан байгаа. Үүнээс наана ашиг хүртэгч эздийг хүлээн авч байгаа.

Б.Батболд: Төсөл дээр 300,000,000 орчим төгрөг тавьсан байна. Зарим нь хандивлагч гэж тавьсан байна. Үүнийгээ Үндэсний зөвлөлийн хурлаар оруулаад санхүүжилтээ тодорхой, баталгаатай болгож байж хугацаагаа тохирох хэрэгтэй. Энэ тал дээр анхаармаар байна. Магадгүй хөрөнгө мөнгө нь бүтэхгүй байгаад стандартаа хэрэгжүүлэх боломжгүй болж магадгүй.

Ш.Цолмон: 2015 оны тайлан дээр Улаанбаатар аудит бенефициар өмчлөгчийн талаар судалгаа хийсэн. 53 компани хамрагдсан, энэ талаар танилцуулах байх.

Н.Эрдэнэцог: Бенефициар өмчлөгчийн талаарх мэдээллээ цахим тайлангаар авч байгаа. Бид судалгааны маягтаа зохиогоод, цахим тайлангийн системд оруулсан. Бенефциар өмчлөгчийг ямар хэлбэрээр ил тод болгох вэ гэдэг аргачлалаа эхлэлтийн тайлан дээр хэлэлцээд, эцсийн өмчлөгч нь хэн бэ гэдгийг харах зорилгоор цахим тайлангаар мэдээлэл авсан. Компаниуд тайлангаа буруу дутуу ойлгосон байсан. Дахин маягтаа шинэчлэн боловсруулж, мэдээллээ аваад нэгтгэсэн. Нийт 202 компаниас өнөөдрийн байдлаар 51 компани ил тод болгосон. 47 иргэн эцсийн өмчлөгч мөн гэдгээ зарласан. 10 компани хөрөнгийн бирж дээр ажиллаж байгаа. Цаашид энэ тал дээр ажиллана.

Э.Сумьяа: Дэд ажлын хэсгийн нөхдийг хийхээс өмнө хийчихсэн байна. Энэ нь хуулинд нэмэлт оруулаад л болох юм. Судалгаа энэ тэр шаардлагагүй, хайран мөнгө.

Б.Осоргарав: Бид 3 удаа ажлын албатай хамтран сургалт явуулсан. Зарим нь ойлгохгүй байна, зарим нь мэдээлэхийг хүсэхгүй байна. Үүнийг ил тод болгох амаргүй, олон улсын стандартад заагдсан учраас хийхийг зорьж ажилласан.

Б.Заяабал: За баярлалаа, гишүүдийн гаргасан саналыг тусгаад, тодруулах зүйлээ анхаарч ажиллаарай. Ингээд шийдвэрийн төсөлд санал авъя.

Гишүүд 100 дэмжсэнээр батлав.

### **Шийдвэрлэсэн нь:**

Монголын Олборлох үйлдвэрлэлийн компаниудын ашиг хүртэгч эздийг ил болгох замын зураг хөтөлбөрийг УУХҮЯ-ны Уул уурхайн газрын ахлах мэргэжилтэн Д.Дамба танилцуулав. Хуралдааны явцад гишүүдээс гаргасан саналыг замын зургийн төсөлд тусган боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ОУИТБС-ын Ажлын албанд үүрэг болгов.

## **ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол улсын ОҮИТБС-ыээ 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөний төсөл**

Ш.Цолмон: 2016 оны төлөвлөгөөний биелэлт болон 2017 оны төсвийн төслийг урьдчилсан байдлаар та бүхэнд тараасан байгаа. Ингээд товчон танилцуулъя. 2016 онд нийт 53 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 27 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 50 орчим байна. Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 2 удаа хуралдсан байна. Гол шалтгаан нь Дэлхийн банкины төслийн санхүүжилт, түүний гэрээ бэлтгэх ажил саатаж, 8 дугаар сарын 20-н хүртэл саатсан байна. Хэрэгжсэн томоохон ажлуудыг дурдахад, 2016 оны 2 дугаар сард Перу улсад зохиогдсон Олон улсын хурлын үеэр Монгол Улс “мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснийхээ” төлөө ОҮИТБС-ын даргын нэрэмжит шагналыг хүртсэн байна. Монгол Улс хошой шагналтай улс болоод байна. Өмнө нь 2011 онд тайлангаас тайланд хамрах зүйлээ сайжруулан тайлагнаж байгаагийн төлөө мөн шагналыг хүртсэн байна. Уг хуралд Уул уурхайн сайд Р.Жигжид тэргүүтэй төлөөлөгчид оролцож, ОҮИТБС-ын үзэсгэлэн гаргаж, Перу, Колумб зэрэг улсуудтай хамтран ажиллах асуудлыг ярилцав. ОҮИТБС-ын удирдах хороонд Монгол Улсын төлөөлөл – УУЯ-ын санхүү эдийн засгийн хэлтсийн дарга Н.Энхбаярыг сонгуульд амжилттай оролцуулж, гишүүнээр сонгогдов. Гэвч одоогоор яамны бүтцийн өөрчлөлт дуусаагүй тул хүлээлттэй байна.

2015 оны ОҮИТБС-ын тайлан гаргах аудиторын түншлэлийг сонгон шалгаруулах ажлыг олон маргааныг давж байж, зохион байгуулсан бөгөөд Монголын Улаанбаатар аудит корпораци, Их Британийн Харт Нойрс байгууллагын түншлэл эцэст нь шалгарч, гэрээ байгуулан ажлаа танилцуулж байна. ОҮИТБС-ын стандартын дагуу эхлэлийн семинар зохион байгуулж, гэрээт ажлын цар хүрээг эцэслэн тохирсон. Уул уурхайн ашиг хүртэгч эздийн ил тод байдлын судлах ажлыг зохион байгуулах өргөн бүрэлдэхүүнтэйгээр дэд хэсгийг УУЯ-дээр зохион байгуулж, холбогдох уулзалтуудыг зохион байгуулж, Замын зураг хэмээх төлөвлөгөөг боловсруулан танилцуулж байна.

Цахим тайлангийн системийн 2 дугаар шатны хүрээнд олон нийтийн танилцуулгыг Уул Уурхайн яаман дээр зохион байгуулж, гарын авлага, брошурыг шинэчлэн хэвлэв. Цахим тайлагнالын системийн статистик, дүн шинжилгээний хэсгийг сайжруулав. УИХ-ын эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдсан “Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж, хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн хэдий ч, УИХ хэлэлцэж чадсангүй. ГОУХАН, Майнинг сэтгүүл хамтран хойд болон баруун бүсийн ил тод байдлын номыг бэлтгэж, хэвлэн нийтлүүлэв. ОҮИТБС-ын гэрээний ил тод байдлын цахим хуудсыг Нээлттэй нийгэм форум, УУЯ-тай хамтран зохион байгуулж, дуусгаад байна. ОҮИТБС-ын туршлага хуваалцах, туршлага ажлын хүрээнд ГОУХАН-тэй хамтран тэдний зардлаар Тайланд, Мьянмар улсад ажлын албаны төлөөлөгчид ажиллаж, туршлагаа хуваалцсан байна. Монгол Улсын ОҮИТБС-ын Олон улсын баталгажуулалтын 2016 оны 7 дугаар сарын эхээр зохион байгуулж, холбогдох тайланг дүнг танилцуулж ирсэн бөгөөд 12 дугаар сард эцсийн дүнг ирүүлнэ. Орон нутгийн харилцааны ажлыг сайжруулах зорилгоор ЕСБХБ-ны туршилтын төслийг боловсруулах, судалгааг холбогдох байгууллагаар эхлүүлэхээр болоод байна.

2017 онд 5 үндсэн зорилго бүхий 16 зорилтоор ажиллахаар төлөвлөж байгаа. Үүнд, ОҮИТБС-ын олон улсын баталгаажуулалтын дүнгээр доогуур үнэлгээ авсан үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг ахиулах, 2016 оны нэгтгэл тайланг боловсруулах, батлах, олон нийтэд мэдээлэх, ОҮИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, дэд зөвлөлийн чадавхийг бэжжүүлэх, Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зургийг хэрэгжүүлэх, гэрээний ил тод байдлыг хангах гэсэн 5

зорилгыг тавьж, нийт 16 зорилт бүхий 2017 оны ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж, холбогдох ажил, үр, дүн, гарах бүтээгдэхүүн, хариуцах тал, хугацаа, зардлын хэмжээ, эх үүсвэрийн хамт танилцуулсан. 2017 оны уриаг 2016 оны төлөвлөгөөний уриаг хэвээ “Дэд зөвлөлийг чадавхжуулах” гэсэн уриаг хэвээр байлгахаар болсон. Бид ажлын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлд 12 дугаар сард танилцуулахаар байгаа, үүнээс өмнө нэмэх, орхигдуулсан зэрэг санал байвал өгөөрэй, төлөвлөгөөнд тусган оруулах боломжтой. Санхүүжилтийн хувьд Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Улсын төсвийн эх үүсвэртэй гэж ойлгож байна. 2016 он шиг саатал гарахгүй байх гэж найдаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Заяабал: Баярлалаа, танилцуулгаас хараад Монгол улс 2 удаа шагнал авсан байна. Бид тэгэхээр их сайн ойлголцод юм байна. Төрд ажиллаж байгаа ч монгол хүн, ИНБ компанид ажиллаж байгаа нь ч адилхан монгол хүн, бид хоорондоо илүү сайн ойлголцож чадаж байна, өнөөдөр төрд ажиллаж, төр төлөөлж байгаа хүн маргааш иргэний нийгмийн төлөөлөөд явж байх боломжтой, монголчууд сайн ойлголцож байгаагийн үр дүнд бид хошой шагнал авсан байна. Бид өнөөдөр шинэ алхам руу явж байгаа, энэ нь цахим тайлагнال юм. Манай татварын байгууллага цахим болсон, бүх мэдээллээ гаргаж, солилцож байна, хувийнхан ч гэсэн ийм боломжтой болох байх, цаашдаа ч бүгдээрээ цахим болно, хүссэн мэдээллээ авах боломж нь бүрдэх байхаа. 2017 оны ажлын төлөвлөгөөнд ямар санал байна, асуулт хариултыг дөрвөн саналаар хаая.

Б.Саран: Төлөвлөгөөний зорилт 2 буюу Тусгай зөвшөөрлийн ил тод байдлын бүрэн хангах гэсэн хэсэгт эvdэгдсэн газар, нөхөн сэргээсэн газрын талаарх мэдээллийг тайланд оруулах гэсэн ажлыг нэмж оруулах саналтай байна. Мөн зорилт 3.2 дугаар ажил буюу “Компанийн тайланг баталгаажуулах журам боловсруулж, баттуулах” гэдэг ажлын хариуцах байгууллагын бүрэлдэхүүнд манай байгууллагыг оруулж өгнө үү гэсэн санал байна.

Б.Баярмаа: Гэрээг ил тод болгох гэсэн 5 дугаар зорилго дээр төлөвлөсөн ажлуудыг харвал гэрээ ил тод болохгүй. Газрын тосны 20 гэрээ нууц байгаа, 2015 оны тайлангаар ил тод болж чадалгүй дууслаа. Үүнийг ил тод болгох талаар ажил төлөвлөмөөр байна, газрын тосны гэрээ дандаа нууцлаад ил болгодоггүй. Бусад гэрээнүүдийн хувьд харьцангуй Хөрөнгө оруулалтын гэрээ, Орон нутгийг хөгжүүлэх гэрээ гэх мэт гэрээнүүдийн загвар гарчихсан, ил тод байгаа. Нэгэнт ил тод болсон, гэрээнүүдийн гэрээ байгуулах үйл явцыг ил тод болгох тал дээр бид ажилламаар байна. Гэрээ байгуулагдсан хойно нь хичнээн яриад нэмэргүй болдог, байгуулсны дараа гэрээ хэр зэрэг хэрэгжив гэдгийг үнэлээд, үнэлгээг хэлэлцээд олон нийтэд танилцуулаад явах хэрэгтэй байна. ТАН эвсэл гэрээнүүд дээр мониторинг хийгээд байгаа, энэ мэдээллийг вэб сайтад тавиад нийтэд хүргэх ажлын төлөвлөөд оруулмаар байна. Олон нийтийн хэлэлцүүлэг хийдэг байсан, энэ ажил төлөвлөгөөнд орсон уу? Бид жилд нэг удаа 3 талаараа уулзаад, төр юу хийв, компани иргэний нийгэм хэр зэрэг хянаж ажиллав гэдгээ ярилцаж, хэлэлцдэг ажил байсан. Энэ нь нэг удаа ч гэсэн компанийг суулгаад ямар хандив тусламж орон нутагт өгөв, газар нутгийг хэр зэрэг эвдэв, хэр зэрэг газрыг нөхөн сэргээв гэх мэт ам асуудаг ажил байсан, бид уламжлал болгоод хийгээд ирсэн ажлаа оруулмаар байна. Сум сонгох асуудал дээр сэргэх эсэх нь тодорхойгүй болсон Заамар сумыг анхааралдаа авч, жишиг сумын нэгэнд оруулах саналтай байна. Сая Засгийн газар Заамар суманд 5000 га газрыг нууцаар өгчихсөн байгаа. Туршилтын төслийн жишиг сумандaa энэ сумыг оруулаад тэнд ямар хаалттай, авлигын шинжтэй асуудал байна, түүнийг ил болгож ажилламаар байна. Бид 2006 оноос хойш яваад ил

болгож дийлэхгүй, маш их авилгажсан сум, аймаг байгаа. Бид эцсийн эцэст авилгаас сэргийлэх, уул уурхайн орлогыг ил тод болгох зорилгоор ажиллаж байгаа.

Ш.Цолмон: ЕСБХБ хүнээ сонгож, 10 сарын хугацаатай зохицуулагч ажиллуулна, тэгээд хэдэн жишиг сумдыг сонгож ажиллана, миний бодлоор энд Заамар сум орох байхаа.

Л.Төр-од: 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хараад биелэлт нь 50 хувь орчим байна гэж байна. Үүний шалтгаан нь ойлгомжтой, санхүүжилтийн асуудал байгаа. Энэ оныг дуустал үлдсэн 50 хувиас хийгдэх боломжтой үйл ажиллагаа, арга хэмжээ байгаа юу? хэрэгжүүлэх боломжтой хэдэн хувь нь байна? эсвэл 2017 оны ажилд оруулж байна уу, хийгдээгүй үлдсэн ажлуудыг бүр орхиж байна уу, дараа оны ажлын төлөвлөгөөнд оруулж байна уу? Дараагийн санал бол үйл ажиллагааны төлөвлөгөөний уриатай холбоотой, энэ жил Дэд зөвлөлийг чадавхжуулах жил байсан, тодорхой хэмжээний ажлууд хийгдсэн. 2017 оны уриаг энэ хэвээр нь үлдээсэн байна. 2017 оны төлөвлөгөөний төслийг харвал Ашиг хүртэгч эздийг ил тод болгох чиглэлээр томоохон ажлууд, 25 арга хэмжээ хийгдэх юм байна. Иймээс уриагаа” Ашиг хүртэгч эздийг ил тод болгох жил” болгох саналтай байна. 2016 оны төлөвлөгөөний биелэлтийн хувьд мэдээж хэрэг мониторинг хийгдэж байгаа байх гэхдээ төлөвлөгөөний биелэлтийн талаар талуудаас санал дүгнэлт аваад нэгтгээд ажиллавал цаашдаа төлөвлөлт хийхэд илүү бодитой болох юм. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөний биелэлт, төлөвлөлтийг илүү бодитой болгох хэрэгтэй байна. Баярлалаа.

Ш.Цолмон: Энэ нь өнөөдрийн байдлаар гарсан дүгнэлт байгаа, он дуустал нилээдгүй олон ажил хийгдэнэ. Тухайлбал, Үндэсний зөвлөлийн хуралдаан зохион байгуулна, 2015 оны тайлангуудаа зорилтол бүлгүүдэд танилцуулна, хэвлэлийн бага хурал хийх, компаниудын нийгмийн хариуцлагын талаар хийгдэх ажил байгаа. Мөн аймаг сумдын дэд зөвлөлийн уулзалтыг 12 дугаар сард зохион байгуулна. Төрийн байгууллагуудын шинэ удирдлагуудтай хийх уулзалтыг 12 дугаар сард зохион байгуулахаар байгаа.

Л.Төр-од: Монгол улс Нээлттэй засаглалын түншлэлийн гишүүн орноор оролцож байгаа. Энэ 12 дугаар сарын 7-9-ны хооронд Парист дээд хэмжээний уулзалт болно. Үүнтэй холбоотойгоор Монгол улс Олборлох үйлдвэрлэлийн ажлын хэсэгт ажиллаж байгаа, эндээс бодлогын баримт бичиг гарах юм байна. Энд өөрсдийн саналыг оруулах эсвэл нэмж мэдэгдэл гаргах боломжтой байгаа. УИХ-аар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар хийхээр үүрэг хүлээсэн байгаа. Үүнд, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдалтай холбоотой асуудал дээр ажлын хэсгийн гишүүд, оролцогч талуудын уялдааг хангах талаар идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Э.Сумьяа: 2017 оны төлөвлөгөөний зорилт бол тодорхой, үүнийн өөрчлөхгүй байх. Харин урианы хувьд дэд зөвлөл юм уу, орон нутаг гурван талын оролцоог чадавхжуулах жил юм уу? ИНБ, Засгийн газар, компаниуд ямар ч асуудлаар хоорондоо харьцаад санал солилцоод байгаа. Бидний бүх харилцаа нээлттэй, ил тод байгаа, үүнийгээ орон нутагт бий болгоод өгөөч. Төвийн бүсийн уулзалт, сургалт гэж байна. Энэ нь ажлууд жил бүр хийгдээд байгаа ч ажил явахгүй байна, урианыхаа хүрээнд хийх ажлаа тодруулаад, үйл ажиллагаагаа нээлттэй болгоод өгөөч. Ямар аргаар хийх вэ гэдэг чухал байна. Бид анхнаасаа нээлттэй ажиллаж ирсэн. Манай улс ч гэсэн ОУ-ын нарийн бичгийн дарга нарын газар, удирдах

хороонд ч бүх юм мэдээллээ оруулж, нээлттэй байгаа, манай улс анх хэрэгжүүлээд энэ талаар олон улсын дүрмэнд орсон зүйл ч байгаа. Одоо манай улс цахим тайланг анхалж хэрэгжүүлээд байна. Хэрвээ бид цахим тайланд мэдээллээ оруулаад хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргачихвал дахиж мөнгө үрж, хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагагүй болно. Бид тэр зам руу явж байна. Ажлыг хийх аргаа сайжруулах хэрэгтэй байна. Энэ төлөвлөгөө эзэнгүй байна, хариуцах эзэн дээр гишүүд нэрээ тавиулах хэрэгтэй байна. Ялангуяа бодлогын асуудал дээр уул уурхайн яам хариуцах, тайлан гэхэд ТЕГазар гэх мэт тодорхой эзэн тавих хэрэгтэй.

Б.Батболд: 2017 оны төлөвлөгөөг хараад хуулиа батлуулах ажил орхигдсон юм шиг байна. Уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран ажлын хэсгийн гишүүдийн идэвхжүүлэх арга хэмжээ зохион байгуулмаар байна. Оюутолгой санаачилаад байсан, тиймэрхүү юм хиймээр байна. Мөн төлөвлөгөөний хариуцах эзэн дээр зөвхөн ТАН эвсэл гэж байна, уг нь Үндэсний зөвлөлийн хурал дээр Гомбожав гуай үүнийг ИНБ гэж тавих санал гаргаж байсан. Цаашдаа иргэд орж ирэх юм байна.

Б.Заяабал: За баярлалаа, гишүүд зөв санал гаргаж байна. Гишүүдийн саналыг тусгаад, бүх гишүүд рүү явуулж, санал авч ажиллах саналтай байна. Ингээд хурлын шийдвэрийг баталъя. Энэ удаад ТЕГ хуралдаанд өргөн бүрэлдхүүнтэй оролцож, хуралдааныг удирдах, заал танхимаар хангаж ажиллаа. Дараагийн хуралдаанаар төрийн байгууллагуудыг идэвхтэй оролцуулахыг хүсье.

#### Шийдвэрлэсэн нь:

Монгол улсын ОУИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөний төслийн Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. Хуралдаан дээр гишүүдээс гарсан саналуудыг 2017 оны ажлын төлөвлөгөөний төсөлд нэгтгэн шинэчилж, Үндэсний зөвлөлд танилцуулахад бэлтгэхийг ОУИТБС-ын Ажлын алба /Ш.Цолмон/-нд үүрэг болгов.

Хуралдаан 12,40 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч

Н.Энхбаяр

Татварын ерөнхий газрын дэд дарга

Б.Заяабал

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан

А.Огтонтунгалаг